

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ

ТОВХИМОЛ

8

ХЭСГИЙН АХЛАГЧИЙН ОРОЛЦОО



Хөдөлмөр,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Save the Children

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: С.Энхтуяа
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ХЭСГИЙН АХЛАГЧИЙН ОРОЛЦОО

Хэсгийн ахлагч ба хамтарсан баг

Хэсгийн ахлагч та бүхэн хүүхэд, гэр бүлтэй хамгийн ойр ажилладаг хүмүүс. Иймээс та хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, мөлжлөгөөс хамгаалахад тусалж чадна. Хорооныхоо хамтарсан багийн гишүүдэд дэмжлэг үзүүлэн, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд та хэрхэн оролцож болох талаар энэхүү гарын авлагаас уншиж, танилцаарай.

Монгол Улсад хүүхэд хамгааллын үйлчилгээний тухай ярьж эхлээд арваадхан жил болж байгаа тул энэ асуудал нь та нарын хувьд шинэ, танил биш санагдах байх. Иймээс хүүхэд хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлэхэд тус дөхөм болох үүднээс энэхүү гарын авлагыг та бүхний нэг, миний уулзсан хэсгийн ахлагчийн асуусан асуултад хариулт өгөх хэлбэрээр бичлээ.



Асуулт: Би хувь хүнийхээ хувьд болон хэсгийн ахлагчийн хувьд хүүхдийн эрхийг хамгаалахад ямар үүрэг, оролцоотой байх вэ?



Хариулт: Хүүхэд бол хайр энхрийлэл, халамж анхааралд өсөх ёстойг хүн төрөлхтөн үр хүүхдээ өсгөж, хүмүүжүүлж ирсэн түүхэн замналаараа харуулж иржээ. Монголчууд “хүүхэд идээ ундтай бол сөөм, инээд баясалтай бол төө, итгэл хайран дунд тохой, эрдэм ажил дунд алд өсдөг” гэсэн гүн ухаанаар хүүхдээ зодуур, хүчирхийлэл, алагчлал, шоовдорлол, мөлжлөг дарамтаас ангид өсгөхийг зорьдог олон мянган жилийн уламжлалтай.

Хүүхэд том хүний эдлэх ёстой суурь эрхүүдийн олонхийг, мөн хүүхэд гэдгээрээ өөрийнх нь эмзэг, онцлог байдалд тохирсон бусад эрхүүдийг эдлэх ёстойг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн баримт бичиг байдаг. Энэ бол Хүүхдийн Эрхийн тухай Конвенц. Конвенцод хүүхдийн эдлэх ёстой эрхүүдийг нийт 40 гаруй зүйлд багтаан тайлбарласан байдаг бөгөөд 1) эсэн мэнд амьдрах, 2) хөгжих, 3) хамгаалуулах, 4) оролцох гэсэн дөрвөн үндсэн бүлэгт хуваасан байдаг. Хүүхэд эдгээр бүх эрхээ эдлэхэд нь эцэг эх, гэр бүл, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага бүгд үүрэг хүлээхээр тус конвенцод заажээ.

Хүүхдийн Эрхийн тухай Конвенц бол дэлхийн хамгийн олон улс нэгдэн орсон баримт бичиг бөгөөд Монгол Улс 1990 оноос гишүүн болж хүүхдийн бүх эрхийг хангах сахиулах үүргийг хүлээж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 10.3-т тус улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэсэн байдаг. Иймээс төрийн үйлчилгээг анхан шатанд хүргэхэд чухал үүрэгтэй оролцдог манай хэсгийн ахлагч нар албан үүргийнхээ хувьд ч, хувь хүнийхээ хувьд ч хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үүрэгтэй.

Мөн хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлд иргэн, хуулийн этгээд хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй гэж заасан. Хэрвээ таны мэдээлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн амь нас, аюулгүй байдалд аюул тулгарвал хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Ийм учраас та иргэн хүний хувьд, хэсгийн ахлагчийн үүрэг гүйцэтгэж байгаа учраас таны гол үүрэг бол мэдээлэх үүрэг юм.

? **Асуулт:** Хүүхэд чинь их олон эрхтэй байдаг юм байна. Арай дэлгэрэнгүй тайлбар өгөөч. Эсэн мэнд амьдрах болон хамгаалуулах эрхүүд нь ялгаатай юу? Оролцох эрх гэж юунд оролцохыг хэлж байгаа юм бэ?

! **Хариулт:** Эсэн мэнд амьдрах эрхүүд нь хүүхдийг эрүүл саруул өсгөн бойжуулахад илүү холбоотой. Эдгээр эрхүүд нь хүүхэд эмнэлгийн тусламжтайгаар төрж, хоол хүнс, ус, гэр орон, хувцас хунар гэх мэт хамгийн наад захын хэрэгцээ нь хангагдсан орчинд амьдрах ёстойг баталгаажуулах ёстой. Эсэн мэнд амьдрахын тулд хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж өгөх нь томчууд бидний үүрэг.

Аюулгүй орчин бүрдүүлэх нь хүүхдийн хамгаалуулах эрхтэй холбогдоно. Хамгаалуулах эрх гэдэг нь хүүхэд болзошгүй осол, аюул, хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс ангид байхын тулд хүүхдийн төлөө үүрэг хүлээсэн талуудын дэмжлэгийг авахыг хэлнэ.

Хөгжих эрхүүд нь хүүхдийн сурах, тоглох, чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийгмийн болон амьдрах ухааны ур чадваруудыг эзэмших, мэргэжлийн чиг баримжаа олох зэрэг боломжийг хангахад чиглэдэг. Оролцох эрх гэдэг нь хүүхэд өөртэй нь хамаатай асуудлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, саналаа хэлэх, хурал зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээнд оролцох зэргээр хэрэгждэг.

Хүүхэд эдгээр бүх эрхээ эдлэхэд хэсгийн ахлагч дэмжлэг үзүүлж чадна. Жишээ нь: хүүхдийнхээ өвчинг хүндрүүлсэн ээжтэй таарвал та өрхийн эмнэлэгтээ үзүүлэхийг зөвлөвөл, энэ нь хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг нь хангахад та нөлөөлж байна гэсэн үг. Хүүхдээ хичээлд нь явуулахгүй байгаа гэр бүлээс учир шалтгааныг нь асууж, асуудлаа шийдэх арга замын талаар ярилцаад хүүхдэд нь дутагдаж байгаа хичээлийн хэрэгслийг авах гарцыг нь заагаад өгвөл хүүхдийн хөгжих эрхийг хангахад таны оролцож байгаа оролцоо мөн. Мөн хүүхэдтэй өөртэй нь ярилцаад сургууль дээрээ ямар дэмжлэг хэрэгтэй талаар сургуулийн нийгмийн ажилтандаа илэн далангүй ярилцаж болохыг зөвлөвөл та хүүхдийн оролцооны эрхийг нь хангаж байна гэсэн үг.

Хүүхдийн хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэхэд та хэрхэн оролцож болохыг бид танд илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгье. Яагаад гэвэл та хүүхэд хамгаалалд чухал үүрэгтэй учраас илүү сайн мэдлэг, мэдээлэлтэй байх хэрэгтэй юм.



? **Асуулт:** Хүүхэд хамгаалал гэж юуг хэлээд байна вэ?

! **Хариулт:** Хүүхэд хамгаалал гэдэг нь хүчирхийлэл, үл хайхрах, дарамт, мөлжлөгийн улмаас учрах хор хөнөөлөөс хүүхдийг нийгмийн бүхий л орчинд хамгаалах явдал юм. Хор хөнөөл гэдэгт хүүхдийн бие махбод, сэтгэл санааны хөгжил, эрүүл мэнд, боловсрол эзэмших боломж, өөрийгөө хүндэтгэх сэтгэл, гэр бүл болон нийгэмтэйгээ харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж буй гэм хорыг хэлнэ. Нийгмийн бүхий л орчин гэдэг нь гэр бүл, боловсрол, асрамж, халамж, хорих, засан хүмүүжүүлэх байгууллагууд, ажлын байр, малын бэлчээр, гудамж талбай, олон нийтийн газар, цахим орчин, хэвлэл мэдээлэл зэрэг хүүхдийг хүрээлэн буй бүх орчин юм.

**Асуулт: Хүүхдийг яагаад хамгаалах ёстой юм бэ?**

Хариулт: Хүүхэд эмзэг, өөрийгөө хамгаалах чадвар багатай тул өөрт нь учирч болзошгүй аливаа эрсдлээс хамгаалагдах ёстойг олон улсын хэмжээнд баталгаажуулж Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1989 онд батлан гаргасан. Уг конвенцийн 19 дүгээр зүйлд хүүхэд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асрах ёстой аливаа хүний асрамж халамжинд байх хугацаандаа аливаа төрлийн бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл, гэмтэл хүчирхийлэл, үл хайхрах болон үл хайхарсан хандлага, ёс бус харилцаа болон бэлгийн хүчирхийлэл гэх мэт мөлжлөгөөс хамгаалагдах эрхтэй гэдгийг заасан байдаг. Манай улс энэ конвенцод нэгдэн орсон тул конвенцийн заалт бүрийг биелүүлэх ёстой. Мөн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын хуулийг 2016 онд баталсан. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7-р зүйлд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй гэж заасан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5-р зүйлд эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авахыг мөн зааж өгсөн. Тэгэхээр хүүхдийн хувьд хамгийн аюулгүй тайван орчин нь гэр бүлийн орчин бөгөөд хүүхдийг хамгаалах үүргийг нэн тэргүүнд эцэг эхчүүд хүлээдэг байна.

**Асуулт: Хүүхдийг юунаас хамгаалах гээд байгаа юм бэ?**

Хариулт: Хүүхдийг зүй бус харилцаанаас хамгаалах гээд байгаа юм. Хүүхэдтэй зүй бус харилцана гэдэг нь хүүхдийг хүчирхийлэх, үл хайхрах, дарамтлах, мөлжих зэргээр хүүхдэд хор хохирол учруулах аливаа үйлдэлийг хэлнэ. Үүнийг бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах явдал гэж дөрөв хувааж болно.¹ Эдгээр нь дангаараа үйлдэгддэггүй бөгөөд хавсарч үйлдэгддэг. Жишээлбэл: Хүүхдийг загнаад зодсоны дараа, зүгээр байгаарай! арьсаа хуулуулав гэх мэтээр загнах нь бие махбодын болон сэтгэл санааны дарамт хавсарч үйлдэгдэж байна гэсэн үг. Хүүхдийг зүй бус харилцаанаас хамгаалах нь насанд хүрсэн хүн бүрийн үүрэг юм.

**Асуулт: Хүүхдийг хүчирхийлэх гэсэн чинь юу гэсэн үг вэ?**

Хариулт: Олон хүн хүүхдийг хүчирхийлэх гэж ярихаар хүчингийн хэрэгтэй холбож ойлгох нь бий. Энэ бол зөвхөн хүчингийн хэргийн тухай биш, илүү өргөн ойлголт. Хүч чадал, эрх мэдэл давуу байдлаа ашиглан бусдыг хохироож байгаа үйлдэл бүр хүчирхийлэл юм. Манайхны түгээмэл ойлголтоор хүчиндэх гэдэг нь эмэгтэй хүнд хүч чадлаа гарган бэлгийн харьцаанд орсныг илэрхийлдэг гэж ойлгон, бусад төрлийн хүчирхийллийг үгүйсгэх хандлага байгаа нь харамсалтай. Хүчирхийлэл нь бусдыг зодох, албадан хөдөлмөрлүүлэх, үг хэлээр доромжлож сэтгэл санаагаар унагах, эдийн засгийн боломжтой мөртлөө өөрийн асрамж халамжид байгаа хүнийг идэх хоол, өмсөх хувцсаар дутаах, хөгжиж сурах боломжийг нь хаах зэрэг олон хэлбэрээр илэрдэг.

¹ Crosson-Tover, 2005, Scannapieco&Connel-Carrick, 2005, С.Энхтуяа, 2009

Хүүхдэд хүч хэрэглэн бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэнэ. Бие махбодын хүчирхийлэл нь хүүхдийг зодох, жанчих, шидэх, цохих, түлэх, зүсэх зэргээр бие махбодод нь гэмтэл бэртэл учруулах үйлдэл юм.

Сэтгэл санааны хүчирхийлэл нь хүүхдийг загнаж зүхэх, өөрийнх нь болон гэр бүлийг нь нэр хүндэд халдах, басамжлан доромжлох, нэр хоч өгөх гэх мэт хэлбэрээр илэрнэ.

Бэлгийн хүчирхийлэл нь хүүхэдтэй хурьцал үйлдэх, бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хүүхдэд бэлэг эрхтнээ харуулах, бариулах, хөхүүлэх, хүүхдийн нүдэн дээр хурьцал үйлдэх, хүүхдэд садар самууныг сурталчилсан дүрс бичлэг, зураг үзүүлэх, хүүхдийг ийм сэдэвтэй дүрс бичлэг, кинонд тоглуулах, хүүхдийн бэлэг эрхтнийг ил гаргасан зургийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх зэрэг үйлдлүүд юм. Бэлгийн хүчирхийллийг зөвхөн эрэгтэй хүн үйлдэхгүй. Эмэгтэй хүн ч бэлгийн хүчирхийлэл үйлдэх нь бий. Хохирогчид нь эмэгтэй хүн байхаас гадна эрэгтэй хүн ч бэлгийн хүчирхийллийн хохирогч болж болзошгүй. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг харсан, мэдсэн, сонссон бол та хороо, сумынхаа хамтарсан багийн гишүүн болох нийгмийн ажилтанд заавал мэдэгдээрэй. Тэд таны өгсөн мэдээллийг шалгаж, хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.



Асуулт: Үл хайхрах гэдгийг юу гэж ойлгох вэ?



Хариулт: Хүүхдийн орон байр, хоол хүнс, хувцас хунар гэх мэт наад захын үндсэн хэрэгцээгээр дутаах, хангахгүй байх, сургуульд явуулахгүй байх, өвчилсөн үед нь эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх зэрэг үйлдлүүдийг үл хайхрах хүчирхийлэл гэнэ. Үл хайхрагдсан хүүхдийн хувьд эмзэг, эрсдэлт байдал нь улам нэмэгдэнэ гэсэн үг. Эцэг эхийн анхаарал халамжийг хүртэж чадахгүй үл хайхралтад өртсөн хүүхэд бусад төрлийн хүчирхийлэлд өртөх, гэмт хэргийн хохирогч болох эрсдэл ихтэй байдаг. Иймээс үл хайхрагдаж буй шинж тэмдэг илэрсэн хүүхэд таны хариуцсан хэсэгт байвал нийгмийн ажилтандаа даруйхан мэдэгдэх хэрэгтэй. Үл хайхрагдсан хүүхэд дараах шинжүүд илэрч болно.

- Хүүхэд хаягдмал буюу орхигдсон байдалтай байх
- Орон гэргүй байх
- Эрүүл мэндийн үзлэгт хамрагдахгүй байх (вакцин хийлгэхгүй байх, байнга өвдөх гэх мэт)
- Цаг уурын байдалд үл тохирсон хувцас өмсөх (өвөл нимгэн хувцастай байх, гутал хувцасгүй байх гэх мэт)
- Хувийн ариун цэвэр муу сахих (бөөстөх, сайртах, арьсны өвчин тусах)
- Үе тэнгийн хүүхдүүдээсээ хөгжлөөрөө хоцрох (хэл ярианы хөгжил тааруу, биеийн жин бага, тураалтай байх)
- Сургууль завсардсан гэх мэт

Мөн зан байдал нь өөрчлөгдөж, хэвийн бус болсон байдаг гэдгийг анхаараарай. Үл хайхралтад өртсөн хүүхэд бүрт адил шинж тэмдэг илрэхгүй байх нь бий. Учир нь хүүхэд бүр, хүн бүр ялгаатай. Тиймээс танд ямар нэгэн сэжиг таамаг л байх юм бол энэ талаар нийгмийн ажилтандаа мэдээлэхийг зөвлөж байна.

Асуулт: Хүүхэд ээж аавдаа тусалж ажил хөдөлмөр хийж байгааг мөлжлөг гэх үү? Хүүхдийн мөлжлөг гэж юуг хэлээд байгаа юм бол?


Хариулт: Хүүхдийн нас биенд нь тохирсон гэрийн ажилд оролцох, өрхийн үйлдвэрлэлийн хөнгөн хялбар ажилд туслах, 14 нас хүрсэн хүүхэд хичээл сургуулийнхаа амралт, зав чөлөөгөөр хүүхдэд хориглоогүй хөдөлмөрийг богино цагаар эрхлэхийг мөлжлөг гэж үзэхгүй. Харин хүүхдээр гуйлга гуйлгах, нас биед нь ахадсан ажил хийлгэх, хичээл сургуулиас нь завсардуулан хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдээр хийлгэхийг хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийг ашиг хонжоо олгох хэрэгсэл болгох зэрэг үйлдлүүдийг мөлжлөг гэнэ.

Хүүхдээр ямар хөдөлмөр хийлгэхийг хориглосон тухай 2016 оны 2 сарын 8-ны өдөр Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын тушаалаас үзэж болно. Энэ тушаалаар насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг гаргасан байдаг бөгөөд хорооныхоо нийгмийн ажилтнаас энэ мэдээллийг авч болно.



Асуулт: Хүүхэд бие махбодын хүчирхийлэлд өртсөн гэдгийг яаж мэдэх вэ? Заримдаа хүүхдүүд тоглож наадаж яваад унаж бэртээд өөрийгөө гэмтээх тохиолдол байдаг.

Хариулт: Тиймээ. Хүүхдүүд гэнэн томоогүйгээсээ болж гэмтэх, бэртэх нь бий. Гэхдээ бусдад зодуулснаас болж гэмтсэн үү, санамсар болгоомжгүйгээсээ болоод гэмтсэн үү гэдгийг таних хэрэгтэй. Хүн өөрийгөө элдэв гэмтэл бэртлээс хамгаалах байгалийн зөн совинтой. Түүнийг бид рефлекс гэж нэрлэдэг. Гүйж яваад унасан хүүхэд духаа юм уу, өвдгөө л шалбалдаг. Тэрнээс биш эрүүгээ хугалж, бөгсөө урдаггүй. Яагаад гэвэл өөрийгөө хамгаалах рефлекс нь богино хугацаанд ажиллаж хүүхдийг хүнд бэртэл гэмтэл авахаас хамгаалдаг. Доорх зураг дээр ногооноор тэмдэглэгдсэн газрууд бол хүүхэд санамсаргүй байдлаар өөрийгөө гэмтээж болох хамгийн өндөр магадлалтай цэгүүд байна. Биеийн өнгөтэй хэсгүүд бол хүүхэд санамсар болгоомжгүйгээсээ юм уу, эсвэл хэн нэгний санаатай үйлдлээс болж гэмтсэн үү гэдгийг тодруулах шаардлагатай газрууд юм. Энэ хэсэгт байгаа шарх сорвины харагдах шинж байдлаар нь, хүүхдийн зан авираар, эцэг эхийг нь тавьж байгаа тайлбараар хүчирхийлэлд өртөж үү, үгүй юу гэдгийг таньж болно. Жишээ нь, хурууны үзүүр хэсэг нь түлэгдсэн бол хүүхэд өөрөө халуун зүйлд хүрснээс болсон байна гэж хэлж болох бол гар нь тэр чигтээ түлэгдсэн бол халуун шингэнд гарыг нь хүчээр дүрснээс үүсч болох юм.



Харин улаанаар тэмдэглэгдсэн газрууд бол гадны санаатай үйлдлээр гэмтэл бэртэл авч болох хэсгүүд юм. Улаанаар тэмдэглэгдсэн газруудад хүүхэд шарх сорвитой, гэмтэл бэртэлтэй байвал бие махбодын хүчирхийлэлд өртсөн гэж таньж болно.


 **Асуулт: Бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийг яаж таних вэ? Гаднаас нь хараад мэдэх боломжгүй биз дээ?**

 **Хариулт:** Тиймээ, энэ амаргүй. Гэхдээ та тухайн хүүхдийг сайн ажиглах юм бол зарим шинж, тэмдгийг ажиглаж, харж болно. Ийм төрлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд айсан, гутарсан, зовж шаналсан байдалтай харагдаж болно. Мөн хүүхэд алхаж, сууж босохдоо зовиуртай байж болно. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд биеэ зүсэх зэргээр өөрийгөө гэмтээх оролдлого гаргаж болзошгүй байдаг. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй мэдээллийг авсан, ажигласан, сэжиглэсэн тохиолдолд энэ тухайгаа та нийгмийн ажилтанд яаралтай мэдэгдэх хэрэгтэй. Тухайн асуудал дээр нийгмийн ажилтан ажиллаад хүчирхийлэлд өртсөн, үгүйг тогтооно. Хэсгийн ахлагч та үүнийг шалгаж тогтоох шаардлагагүй бөгөөд нийгмийн ажилтны ажил үүрэгт хүүхэд хамгааллын эрсдлийг тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг асуудал ордог байна.

Заримдаа бид эргэлздэг. Буруу бодсон бол яах вэ? миний алдаа байвал яах вэ? үнэн байвал эргээд хүчирхийлэгч нь намайг дарамтлах вий, сэжиглэж байгаа хүн нь таны найз, эсхүл хамтрагч, магадгүй дарга чинь байвал яах уу, хүн гүтгэсэн хэрэгт орох вий гэх мэтээр эргэлзэх нь бий. Ийм тохиолдолд миний зөв байвал яах вэ гэж бодох хэрэгтэй. Таны зөв байгаад хүүхэд хүчирхийлэлд өртөж байвал хүүхдэд яаралтай туслах хэрэгтэйгээс гадна, хүчирхийлэл үйлдэгчийг ч зогсоох хэрэгтэй. Таны өгсөн мэдээллийг нийгмийн ажилтан нууцлах ёстой бөгөөд мэдээллийн эх үүсвэрийг задлах ёсгүй. Энэ нь тухайн мэргэжлийн ёс зүйтэй холбоотой асуудал.


Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртвөл нийгмийн ажилтан, цагдаа болон хамтарсан багийн бусад гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээг яаралтай үзүүлж, хамгаалах ёстой.

Бас нэг мэдвэл зохих зүйл бол зөвхөн охид л бэлгийн хүчирхийлэлд өртдөггүй. Хөвгүүд ч өртөж болзошгүй гэдгийг анхаараарай.

 **Асуулт: Бодоод байхад нэг хүүхэд энэ бүх төрлийн хүчирхийлэл, үл хайхрах байдалд нэгэн зэрэг өртөх эрсдэл их байх шиг байна. Хүүхдийг аль хэлбэрт нь илүү өртсөнөөр нь заавал ангилах хэрэгтэй юу?**

 **Хариулт:** Таны бодож байгаа зөв байна. Хүүхдийн хүчирхийллийн бүх хэлбэрүүд нэг хүүхэд дээр илэрч болно. Жишээ нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн нэгэн охин хүчирхийллийн өөр олон хэлбэрт өртсөн нь илэрсэн байна. Охиныг ээжийнх нь найз залуу хүчиндэж, энэ тухай хүнд хэлбэл чамайг ална гэж айлгасан бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл давхар гарсан гэсэн үг. Ээж нь архи уусан үедээ охиноо гэрийн ажил хийсэнгүй гэж зоддог нь бие махбодын хүчирхийлэл бол бие нь өвдөөд байна гэдгийг нь үл хайхарч эмчид үзүүлэхгүй удааж өвчнийг нь хүндрүүлсэн нь нэг хүүхэд олон хэлбэрийн хүчирхийлэлд өртөж болохыг харуулж байна. Хүүхдийг хүчирхийллийн аль хэлбэрт орсноор нь ангилан ялгах шаардлагагүй ч хүүхэд хамгааллын хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэхэд асуудлыг нь цогцоор харж, шийдвэрлэх, хэрхэн ямар нөхцөл байдалд байгааг тусгай үнэлгээгээр тодорхойлдог байна.

 **Асуулт: Яг ямар үйлчилгээг хүүхэд хамгааллын үйлчилгээ гэж хэлэх вэ?**

 **Хариулт:** Хүүхэд хамгааллын үйлчилгээнүүдэд хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах байдал, дарамт мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, хүүхэд эдгээр асуудалд өртсөн тохиолдолд яаралтай мэдээлэх, эрсдэлт нөхцөл байдлаас

нь холдуулах, гэр бүлдээ үлдсэн тохиолдолд хяналт тавих, нөхөн сэргээхэд чиглэгдсэн үйлчилгээнүүд орно. Зүйрлэн үзвэл, хүүхэд өвчин тусахаас сэргийлж вакцин хийлгэдэг, нэгэнт өвдсөн бол эмчилгээ хийлгэдэг, эдгэрсний дараа гам барьдагтай адил.

Асуулт: Хүүхдийг хамгаалах үүргийг хэн хүлээх вэ?

Хариулт: Хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалах нь хүн бүрийн үүрэг. Хэрвээ эцэг эх, асран хамгаалагч болон бусад хүмүүс үүргээ биелүүлэхгүй байвал төр оролцдог. Төр оролцоно гэдэг нь хамгаалуулах эрх нь зөрчигдсөн хүүхдэд шаардлагатай үйлчилгээг хууль, журмын дагуу үзүүлнэ гэсэн үг. Тухайлбал, хүүхэд хүчирхийлэлд өртснийг харсан, мэдсэн иргэн мэдээлэх үүргийнхээ дагуу холбогдох мэргэжлийн хүмүүст хэлнэ, хүүхдээ гэмтээж бэртээсэн, хүчирхийлэл үйлдсэн иргэнийг цагдаагийн ажилтан баривчлаж, хохирсон хүүхдэд эмч эмнэлгийн тусламж үзүүлж, нийгмийн ажилтан хүүхэд гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлж, шаардлагатай дэмжлэг тусламжид холбож өгдөг. Өөр өөр үйлчилгээ үзүүлж байгаа эдгээр байгууллагууд хүүхдийг хамгаалахын тулд нэгдэж хамтран ажиллах шаардлагатай болдог. Иймээс анхан шатны нэгж болох хороо /сум/ багт төрийн үйлчилгээг үзүүлэх хүүхэд хамгааллын хамтарсан баг ажилладаг. Хороо/сум/багт хамтарсан баг ажиллахыг Хүүхэд хамгааллын тухай хуулиар баталгаажуулсан.

Асуулт: Хамтарсан багт хэн хэн ордог юм бэ?

Хариулт: Сум, хороонд хамтарсан багийг засаг даргаар ахлуулан байгуулдаг. Хүүхэд хамгааллын үйлчилгээний онцлог, төрийн үйлчилгээг хүргэх үүргээс хамааран засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаа, эмч нь хамтарсан багийн бүрэлдэхүүнд заавал орох ёстой. Тухайн орон нутгийн байршил, хэмжээ, хүн ам зүйн бүтэц, нийгэм–эдийн засгийн хөгжил, соёл зан заншил, бусад онцлогийг харгалзан өөр бусад ямар салбар, мэргэжлийн хүмүүсийг хамтарсан багт оруулахаа орон нутаг өөрсдөө шийдвэрлэнэ. Ядуурал ихтэй зарим хороо/сум/баг нь халамжийн ажилтнаа, нутаг дэвсгэрт нь ЕБС байрладаг бол сургуулийн нийгмийн ажилтныг, хүүхдүүдийн төлөө тууштай, идэвхтэй ажилладаг Хүүхдийн элчийг оруулж ажиллуулж байгаа жишээ бий.

Хамтарсан багийн үндсэн бүтэц, бүрэлдэхүүнийг дараах зурагнаас харна уу.



Асуулт: Манай хорооны хамтарсан баг хуралдаад, намайг оролцуулсан. Би хамтарсан багийн үндсэн бүрэлдэхүүнд орохгүй юм бол хуралд нь ороод хэрэггүй юм биш үү?

Хариулт. Тийм бас үгүй. Яагаад тийм гэхээр тухайн хамтарсан багаар орж буй асуудал нь таны хариуцан ажилладаг хэсэгт хамаардаг бөгөөд таны туслалцаа дэмжлэг хэрэгтэй үед таныг оруулна. Ингэхдээ хамтарсан багийн ахлагч тантай “Нууцыг хадгалах гэрээ”-г байгуулж, хурлын нууцлалыг хангах ёстой. Ийм байдлаар тухайн хүүхэд, гэр бүлд тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд анхан шатны нэгж дээр ажилладаг мэргэжилтэн болон ажилтнуудын дэмжлэг хэрэгтэй тохиолдолд хамтарсан багт орж ажиллах шаардлагатай. Энэ бол зөвхөн тухайн асуудлыг л шийдэх үед гарна. Хүүхэд гэр бүлд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд ямар мэргэжлийн хүмүүсийн дэмжлэг шаардлагатай байна вэ гэдгээс хамааран дараах мэргэжлийн хүмүүс хамтарсан багт ажиллаж болно.

- ✓ Халамжийн мэргэжилтэн
- ✓ Хөдөлмөрийн мэргэжилтэн
- ✓ Тухайн нутаг дэвсгэрт хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл
- ✓ Тухайн хэсгийн ахлагч
- ✓ Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувьд дохионы хэлний орчуулагч, хяналтандаа авсан эмч, сэтгэл зүйч, өмгөөлөгч гэх мэт
- ✓ Хүүхдийн элч, олон нийтийн төлөөлөл гэх мэт

Хэсгийн ахлагч нарын хувьд хариуцсан нутаг дэвсгэрт нь амьдарч байгаа хүүхдэд кейс менежментийн үйлчилгээ үзүүлж байгаа үед тухайн хүүхдийн асуудлаар хамтарсан багт мэдээлэл өгөх, иргэд, олон нийт, хүүхдүүдэд хамтарсан багийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, үйл ажиллагааг нь сурталчлах байдлаар ажиллавал илүү үр дүнтэй. Үүний тулд хэсгийн ахлагч та хамтарсан багийн үйл ажиллагааны талаар сайн мэдлэг, мэдээлэлтэй байх нь чухал. Өөрөө бүрэн ойлголттой байж бусдад тэр талаар хэлнэ шүү дээ.

Асуулт: Нууцыг хадгалах гэдэг нь юу гэсэн үг вэ?

Хариулт: Хэрвээ тухайн кейс нь таны хариуцдаг хэсэгт хамаардаг бол, хамтарсан багаас тухайн кейс дээр ажиллуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд кейс багт орж ажиллаж болно. Хэрвээ кейс багт орж ажиллахаар бол тэнд яригдсан асуудал болон хувь хүний нууцлалыг хадгалах үүрэгтэй.

Хамгааллын үйлчилгээ авч буй хүүхэд, иргэн хэн ч байсан хувийн нууцаа хуулиар хамгаалуулах эрхтэй. Үүнийг Хувь хүний нууцын тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар зохицуулсан. Хэрвээ та нууцыг задруулбал хууль зөрчсөн үйлдэл болно. Тиймээс мэдээллийг хэнд өгөх ёстой хүнд нь л өгөх хэрэгтэй. Таны мэдээлэл хуваалцах



мэргэжилтэн бол нийгмийн ажилтан. Нийгмийн ажилтан ч бас хуулиар хүлээсэн үүрэгтэй. Өөрөөр хэлбэл өөрийн мэдсэн асуудлаа хэн хамаагүй хүнд хэлэхгүй зөвхөн хамтарсан багийн гишүүнд хэлнэ. Хүмүүстэй ярьж байгаад “ам халаад” хүүхэд гэр бүлийн талаар хамтарсан багийн хуралдаанаас сонссон зүйлээ хамаагүй ярьж болохгүй. Хувь хүний нууц хуулиар хамгаалагдсан байдгийг ямагт санаж яваарай.



Асуулт: Хамтарсан багийн хурал хэрхэн явагддаг вэ?



Хариулт: Хамтарсан багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан юм. Ерөнхий хуралдаанаар улирал, жилийн ажлыг төлөвлөх, үйл ажиллагааны тайланг сонсохоос гадна шинэ гишүүдийг томилох, ажил үүргийг нарийвчлан тодорхойлох асуудлуудыг хэлэлцэнэ. Ийм хурал нь сард 1 удаа хийгддэг. Гэвч хамтарсан багийн гишүүд хуралдааны дэг, журам ямар байхыг урьдчилан тохирсон дүрэм, журмаа өөрсдөө баталдаг болохоор зарим баг үүнээс олон давтамжтай хурал хийдэг ч байж болох юм. Урьдчилан төлөвлөсөн хуралдаан нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд илүү анхаарал хандуулдаг. Жишээлбэл, харьяа орон нутагтаа хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэл, дарамтыг хэрхэн бууруулах тухай, хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчилах, олон нийтэд таниулах гэх мэт ерөнхий асуудлыг хэлэлцдэг.

Хамтарсан багийн хуралдааны хөтөлбөрийг нийгмийн ажилтан боловсруулж багийн бусад гишүүдэд урьдчилан танилцуулсан байна. Багийн гишүүд хуралдаанд ирэхдээ өөрсдийн салбар чиглэл, ажил үүргийн хүрээнд хийж буй ажлаа бусаддаа танилцуулах, санал дүгнэлтийг нь сонсох бэлтгэл хангасан байна.

Харин хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдол, хүчирхийлэлд өртсөн хүүхэд гэр бүлтэй хэрхэн ажиллах, тухайн асуудалтай холбоотой ажилтнууд л оролцож хуралддаг. Үүнийг кейс хуралдаан гэж нэрлэнэ.

Кейс гэдэг үгийг үгчлэн буулгавал, ямар нэгэн тохиолдол гэж орчуулж болно. Дэлхий нийтээрээ, нийгмийн ажлын үйлчилгээнд кейс гэдгийг орчуулахгүй хэрэглэдэг бөгөөд бид энэ тохиолдолд ямар нэгэн “асуудал”, “шийдэх ёстой зүйл” гээд ойлгоод явъя. Тухайн кейс нь хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эсхүл гэмт хэргийг хохирогч болсон хүүхдийн асуудал гээд ямар ч асуудал, тохиолдол байж болно.

Харин кейс хуралдааныг тодорхой нэг хүүхэд, гэр бүлд тулгарсан хүчирхийллийн эрсдлийг багасгах, хүүхэд, гэр бүлийг хамгааллын үйлчилгээнд хамруулж цаашдаа аюулгүй хэвийн орчинд амьдрах нөхцлийг хангах зорилго бүхий үйлчилгээг төлөвлөх, гишүүд өөрсдийн үзүүлж буй үйлчилгээний явцыг мэдээлэх, үйлчилгээний явцад үнэлгээ хийх, хүүхдийн асрамж халамжийн асуудлыг шийдвэрлэх зэрэг зорилгоор хийнэ.

Кейс хуралдааныг шаардлагатай тохиолдолд, шуурхай зарлан хийдэг. Хэрвээ тухайн кейс нь хүнд, хүүхдэд яаралтай хамгааллын үйлчилгээ шаардлагатай бол тэр хэмжээгээр шуурхай ажиллах шаардлага хамтарсан багийн гишүүдэд гарна. Энэ тохиолдолд, магадгүй өдөрт 2–3 удаа хуралдах шаардлага ч гарч болно.

Хэсгийн ахлагч нарын хувьд эдгээр хуралдаануудад шаардлагатай бол оролцож болно. Таны хариуцан ажилладаг хэсгийн хүүхэд, түүний гэр бүлд хамаатай асуудал байвал нийгмийн ажилтныг тухайн кейс дээр ажиллахад хэсгийн ахлагчийн хувьд

дэмжин туслах үүрэгтэйгээр оролцохыг шаардлагатай бол гэж хэлж байгаа шүү. Энэ тохиолдолд таны дүр бол нийгмийн ажилтанд дэмжлэг үзүүлэх “туслах дүр” юм шүү.



Асуулт: Кейс менежмент гэдэг ямар утгатай үг вэ?



Хариулт: Өмнө хэлсэнчлэн кейс гэдэг хүүхэд хамгааллын гол үйлчилгээг илэрхийлдэг энэ үг нь одоогоор сайн нутагшиж амжаагүй байна. Кейс гэдэг үгийн талаар дээр тайлбарласан.

Менежмент бол байгууллагын зорилгод чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, боловсон хүчний нөөц бүрдүүлэх, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл юм.

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл ирснээр хүүхэд гэр бүлтэй холбоо тогтоож, үйлчилгээ үзүүлэхээс эхлээд үйлчилгээг дуусгах хүртэл бүх үе шатанд ажиллах ажлын арга барилыг кейс менежмент гэж ойлгож болно. Хүүхэд хамгааллын үйлчилгээн дээр бол хохирогч хүүхдийн аюулгүй байдал, хөгжлийн хэрэгцээг шийдвэрлэх хүртэл тухайн хүүхэд, гэр бүлтэй дагнан ажиллана гэсэн үг.

Жишээлбэл, таны хариуцдаг хэсэг дээр аав ээж нь архины хэт хамааралтайгаас болоод сургуульд явахгүй, зах дээр ажил хийж гэр бүлдээ нэмэр болдог ч эцэг эхдээ зодуулж дарамтлуулж байгаа Б гэдэг хүүхэд байгаа гэж бодъё.

Энэ хүүхдэд тулгарсан олон асуудлыг шийдэхийн тулд хүүхдэд кейс менежементийн үйлчилгээ хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдал нь ямар байгааг тодруулахаас эхлээд хүүхэд, гэр бүлдээ хэвийн нөхцөл байдалд ортол нь холбогдох ажилтнууд ажиллах ёстой гэсэн үг.

Хамтарсан баг нь хүүхдийн нөхцөл байдлыг үнэлсний дараа үйлчилгээний төлөвлөгөө гаргана. Төлөвлөгөөнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, бичиг баримттай болгох, тэвчишгүй хөдөлмөрөөс холдуулах, эрүүл мэнд, нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээнд хамруулах, сургуульд оруулах, эцэг эх гэр бүлийнхэнтэй нь ажиллах зэрэг үйл ажиллагааг тусгана. Үйлчилгээний явцад нийгмийн ажилтан хүүхдийн авч байгаа үйлчилгээнүүдийг зохицуулах, холбон зуучлах, үр дүнг нь үнэлэх, дүгнэх, шаардлагатай бол төлөвлөгөөг өөрчлөх зэрэг ажлыг хариуцаж ажиллана.



Асуулт: Хэсгийн ахлагч хамтарсан багт ороогүй бол хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд оролцохгүй гэсэн үг үү?



Хариулт: Оролцоно оо. Хамтарсан багт орж албан үүрэг хүлээгээгүй ч гэсэн иргэний үүргийн дагуу хүүхдийн аюулгүй байдалд анхаарал тавих ёстой. Хэсгийнхээ айл өрхөөр орж, албан ажлаа хийж байх явцдаа хүүхдийн байр байдал, гэр бүлийн харилцаан дээр ажиглалт хийх, сэтгэл зовоохоор асуудал илэрсэн үед хамтарсан багийн гишүүдэд мэдээлэх нь зүйтэй. Энэхүү үүрэг нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 30/24-р тогтоолоор батлагдсан “Хорооны хэсгийн ахлагч нарын ажиллах журам”-д бий.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 30/24 дугаар тогтоолоор “Хорооны хэсгийн ахлагч нарын ажиллах журам”-ыг боловсруулсан.


Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь төр засгийн бодлого шийдвэрийг айл өрх, иргэн бүрт шуурхай хүргэж, нийслэл, дүүрэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хорооны хэсгийн ахлагчийн гүйцэтгэх ажил үүргийг тодорхойлон тэдний ажлын чанар, үр дүнг дээшлүүлэн идэвхжүүлэхэд оршино.
- 1.2. Хэсгийн ахлагч нь Монгол Улсын хууль, тогтоомж төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр батлан гаргасан шийдвэрийг хариуцсан нутаг дэвсгэрийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөн шуурхай хүргэх, мэдээлэх, сурталчлах, тухайн ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 1.3. Энэхүү журмыг Нийслэлийн дүүрэг, хороодын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийг сурталчлах, төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний холбогдох мэдээллийг хөнгөн шуурхай хүргэх, мэдээлэх сурталчлах ажлыг зохион байгуулахад оролцогч хэсгийн ахлагч нар дагаж мөрдөнө.
- 1.4. Хэсгийн ахлагч нь энэхүү журамд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ харьяа дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хорооны Засаг даргатай гурвалсан “Хөлсөөр ажиллах гэрээ” байгуулан ажиллана.

Тус журамд зааснаар хэсгийн ахлагчдын хүлээн үндсэн чиг үүрэгт:

- 4.1. Хэсгийн ахлагчид жил бүр өөрийн ажлын төлөвлөгөө боловсруулж, хорооны Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллана.
- 4.2. Хэсгийн ахлагчид нь төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудын айл өрх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын талаар гаргадаг тогтмол болон нэг удаагийн судалгаа гаргах, нэмэлт баяжилт хийхэд хамтарч ажиллах.
- 4.3. Судалгаанд үндэслэн нийгмийн халамж, тусламж шаардлагатай иргэдэд байнгын анхаарал хандуулж, тэднийг холбогдох байгууллагуудтай холбох, тусалцаа дэмжлэг үзүүлэх санал санаачлага гаргах.
- 4.4. Харьяа хорооны олон нийтийн байцаагчтай хамтран нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж талбай, олон нийтийн газар иргэдийн эргүүл, жижүүр хийхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх


 **Асуулт: Хэсгийн ахлагч өөр ямар байдлаар хүүхэд хамгаалалд хувь нэмрээ оруулж болох вэ?**

 **Хариулт:** Хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдөж байгааг мэдвэл Хүүхдийн тусламжийн утас 108-д болон хорооныхоо “хамтарсан баг”-т мэдээлнэ. Мэдээллийг амаар болон бичгээр өгч болно. Хүүхэд хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдалд өртөх эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа тухай мэдээллийг амаар өгч болно. Харин хүүхэд зөрчилд өртсөн, хамгааллын үйлчилгээ заавал авах шаардлагатай нөхцөл байдлыг мэдсэн бол Хорооны нийгмийн ажилтан дээр очиж мэдээллийг бичгээр өгнө. Нийгмийн ажилтан мэдээлэл өгөх тусгай маягтын дагуу таниас асуудлыг тодруулж, асууж мэдээллийг бөглөнө.

Та хэсгийн ахлагчийн хувьд, тухайн гэр бүлийг хамгийн сайн мэдэх хүний хувьд хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлын талаар өөрийн ажиглалт, дүгнэлтийг нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдэд танилцуулах, мөн гэр бүл, хүүхдийн амьдралд гарч буй өөрчлөлтүүдийн талаар нэмэлт мэдээлэл өгөх, хүчирхийлэгч буцаж ирж, хүүхэд болон гэр бүлдээ түгшүүр төрүүлж байгаа эсэхэд хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэж болно.

Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд хэсгийн ахлагч та хувь нэмрээ оруулж чадна. Хүүхэд хамгааллын сургалтад сууж мэдлэг мэдээлэлтэй болоод түүнийг хэсгийнхээ иргэд, гэр бүлд дамжуулан хүргэж байвал та хүүхдийг эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх ажилд хувь нэмрээ оруулж чадна. Шаардлагатай гарын авлага, зурагт хуудас, тараах материалуудыг нийгмийн ажилтнаасаа аваарай.

 **Асуулт: Урьдчилан сэргийлэхийн тулд бид юу хийж чадах юм бэ?**

 **Хариулт:** Таны хамгийн сайн чадах, боломжтой зүйл бол эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын тухай мэдээлэл өгөх, эрсдэлд орж болзошгүй хүүхэд, гэр бүлийг нийгмийн ажилтанд холбож өгч хүүхэд хамгаалах үйлчилгээнд хамруулах юм.

Эцэг эхчүүд хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх арга барилаа олохгүйгээс, хүүхдээ үгэндээ оруулахын тулд гар хүрэх, зодох, зарим талаараа эрхийг нь хязгаарлах үйлдэл хийх нь бий. Гэхдээ цаад зорилго нь хүүхдээ сайн хүн болгохыг хүсдэг. Гол нь яаж хүмүүжүүлэх аргаа мэддэггүй. Тиймээс та хэсгийн ахлагчийн хувьд хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх энгийн зөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчдад өгч болно. Мөн зөвлөгөө өгч чадах нийгмийн ажилтан болон холбогдох хамтарсан багийн гишүүдэд холбон зуучилж болно.

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2-р бүлгийн 5-р зүйлд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ гэж заасан.

Хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга гэдэг нь хүүхдэд бие махбодын шийтгэл ноогдуулахгүйгээр хүүхдийн хөгжлийн онцлогт нь тохируулж ухааруулж ойлгуулах, тайлбарлах, асуулт тавих, дүгнэн бодуулах зэрэг аргаар буруу үйлдлийг нь засаж зөв зан үйлийг эзэмшүүлэх үйл явц юм. Хүмүүжлийн эерэг арга нь хүүхдийг дураар нь тавих эсвэл шийтгэхийн аль нь ч биш. Харин хүүхдэд хувийн сахилга бат төлөвшүүлж, насан туршдаа хэрэглэх чадваруудыг олгох урт удаан хугацааны шийдлүүд юм.

Айл бүрт багажны хайрцаг байдаг. Тэр хайрцагт байгаа багаж бүр өөр өөрийн үүргийн дагуу хэрэглэгдэж тухайн айлын эвдэрч гэмтсэн зүйлсийг засаж сэлбэж байдаг. Үүнтэй нэг адилаар эцэг эх бүрт хүүхэд хүмүүжүүлэх олон янзын аргатай “багажны сав” хэрэг

болдог. Багажны савыг бид хүүхэд хүмүүжүүлэх аргууд гэвэл тэнд хүүхдээ үлгэрлэн дагуулах, хамтарч тоглох гээд олон янзын багаж байж болно. Багаж бүрт хүүхдийн эвдэрсэн занг засах ид шид бий. Ямар багажууд хүүхэд хүмүүжүүлэх хайрцагт байгааг доорх хэсгээс хараад, эцэг эхчүүдэд санал болгоорой.

- ✓ Зөв үлгэр дууриал үзүүлэх
- ✓ Хүүхдийнхээ сэтгэл зүрхийг ойлгох
- ✓ Хүүхдийнхээ нас, бие, хөгжлийн онцлогт тохируулан харилцах
- ✓ Хүүхдээ сайн сонсох
- ✓ Хамтдаа тоглох
- ✓ Гэрийн ажлаа хамт хийх
- ✓ Гэрийн дүрэм зохиох
- ✓ Хэлсэн үгэндээ хүрэх
- ✓ Хүүхдээ хүндэтгэн хайрлах
- ✓ Хүүхэддээ цаг гаргах
- ✓ Аливаа зүйлийг дадал болтол нь давтах
- ✓ Аливаа зүйлд чин сэтгэлээсээ хандах



Асуулт: Эрсдэлд орж болзошгүй хүүхэд, гэр бүлийг яаж таних вэ?



Хариулт: Хүүхдийн эсрэг хүчирхийлэл хэнд ч, ямар ч гэр бүлд тохиолдож болно. Амьдрал нь бололцоотой бол аз жаргалтай гэр бүл, ядуу байвал хүчирхийлэлтэй байна гэсэн ойлголт байхгүй. Энэ бол нийгмийн гарал, баян хоосон, хөрөнгө чинээтэй холбоотой асуудал биш, харин хүний хандлагатай холбоотой асуудал юм. Тиймээс хэн ч хүчирхийлэлд өртөж болно.

Гэхдээ архины хэт хамааралтай, сэтгэл мэдрэлийн хүнд хэлбэрийн өвчтэй, ууртай ширүүн зан авиртай хүмүүс хүүхдээ хүчирхийлж, амь насанд нь хүрсэн жишээнүүд нь тэдэнтэй илүү ойр ажиллаж хүүхдийг нь хамгаалах шаардлагатайг харуулдаг. Тэгэхлээр ийм асуудалтай гэр бүлүүдэд илүү анхаарал хандуулах хэрэгтэй гэсэн үг. Бас дагавар хүүхэддээ хатуу ширүүн ханддаг хүмүүсийг ч анзаарч байхад гэмгүй. Хөгжлийн бэрхшээлтэй, 0–6 настай хүүхэдтэй хүмүүст хүүхдээ гэрт нь цоожлохгүй байх, хүүхдээ гадаа гудамжинд хараа хяналтгүй тоглуулахгүй байх, халуун хоол цай, пийшин зуухнаас хамгаалах талаар ээж аавуудад хэлж, ярьж, зөвлөж байгаарай.

? **Асуулт:** Хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй, сэжиг таамаг илэрсэн үед яах ёстой вэ?

! **Хариулт:** Өмнө дурдсны дагуу харьяалагдах сум/баг/хорооны нийгмийн ажилтан болон хамтарсан багийн гишүүдэд ханд. Хэрвээ өөрийн сэжиг таамагт эргэлзэж байвал нийгмийн ажилтантайгаа ярилцаж, зөвлөгөө аваарай. Тэд Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх ёстой.

Хүүхдийн тусламжийн утас 108 руу мэдээлээрэй. Энэ утсаар аль ч сүлжээнээс ярьсан үнэ төлбөргүй. Энэ утасны талаар болон хамтарсан багийн талаар хүүхэд, гэр бүлд сурталчилж шаардлагатай тохиолдолд үйлчилгээ авахыг санал болгоорой.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн талаар нийслэлийн цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийллийн талаар дуудлага авах 107 тусгай дугаарт хандахыг ч санал болгож болно.




? **Асуулт:** Тэгвэл ингэнэ, ингэвэл тэгнэ гэсэн илүү тодорхой зааварчилга өгөөч?

! **Хариулт:** Хэсгийн ахлагч нартай уулзаж ярилцсаны үр дүнд та бүхэнд түгээмэл тохиолддог хүүхэд хамгааллын зөрчлийн үед юу хийж болох талаар жишээ болгож дараах зөвлөмжийг хүснэгтээр гаргалаа.

Гудамжаар, байраар явахдаа бид юу харж болох вэ?	Хүүхдэд ямар аюул, эрсдэл тулгарч болох вэ?	Хэсгийн ахлагч та ийм тохиолдолд юу хийж чадах вэ?
Хүүхэд ээж, аав эсхүл өөр хэн нэгэнд зодуулж байвал	Гэмтэж, бэртэж болно. Гэрээсээ зугтааж болно. Амь насаа ч алдах эрсдэлд орж болно.	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдлээ зогсоохыг хүчирхийлэгчид шаардана. 2. Хүчирхийлэгчийг ажиглана. 3. Таны үгэнд ороод хүүхдээ зодохоо байвал, яагаад зодож байгаа учир шалтгааныг асууж тайвшрах боломж өгнө. 4. Тайвширсан хойно нь хүүхдээ зодох нь асуудлыг шийдэх арга зам биш гэдгийг хэлж өгнө. 5. Хүүхдээ дахиж зодохгүй гэсэн амлалт авч, тэр амлалтаа хэрэгжүүлж чадахаар хүн байна гэж үзвэл орхиж болно. 6. Согтуу, эсвэл таны хэлснийг үл тоон хүүхдээ зодсоор байвал цагдаа дуудна. 7. Цагдаа ирээд хүчирхийлэгчийг баривчлавал хүүхдийг гэр бүлд нь хүргэж өгнө. 8. Хүүхдийн гэмтэл бэртэл ноцтой байвал 108 утсанд мэдээлэл өгнө.

		<p>9. Эсвэл өрхийн эмчид хүүхдийг хамт очиж үзүүлэхийг хүчирхийлэгчээс шаардана.</p> <p>10. Нийгмийн ажилтандаа энэ тухай заавал мэдэгдэнэ.</p>
Хүүхэд гэртээ цоожлогдон үлддэг бол	Гал түймэрт өртөх, цонх тагтнаас унах эрсдэлтэй. Айдсаас болж сэтгэцийн хямралд орж болзошгүй.	<ol style="list-style-type: none"> 1. Эцэг эх, асран хамгаалагчтай уулзаж учир шалтгааныг нь тодруулна. 2. Хүүхдээ үлдээж болох хамаатан садан, хөрш, найз нөхөдтэйгээ ярилцахыг зөвлөнө. 3. Нийгмийн ажилтандаа энэ тухай заавал хэлнэ. Нийгмийн ажилтан хүүхдийг нь цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд зуучилж өгнө, эцэг эхчүүдэд сануулна. 4. Хүүхдээ цоожилж үлдээсээр байвал хамтарсан багт мэдэгдэнэ.
Өвлийн хүйтэнд нимгэн хувцастай байвал	Өвчин тусна. Хөл гараа хөлдөөнө. Амь насаа ч алдах эрсдэлд орж болно.	<ol style="list-style-type: none"> 1. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ дулаан хувцаслахыг зөвлөнө. 2. Нэн ядуу амьдралтай бол халамжийн нийгмийн ажилтанд уламжлана. 3. Нийгмийн ажилтандаа мэдээлэл өгнө.
Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа талаар хэн нэгэн хэлбэл	Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа нь үнэн бол энэ нь гэмт хэрэг болно.	<ol style="list-style-type: none"> 1. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн гишүүддээ яаралтай мэдэгдэнэ. Та энэ талаар нотлох, баримтжуулах гэсний хэрэггүй. Энэ бол нийгмийн ажилтан болоод хамтарсан багийн гишүүдийн хийх ажил. 2. Хүүхдийн тусламжийн утас 108 руу мөн мэдээллэнэ.
Хүүхэд хичээл сургуульдаа явахгүй, хөдөлмөр эрхэлж байвал	Хүүхдийн хөгжих, сурч боловсрох эрх зөрчигдөнө. Осол гэмтэлд орж болно. Эрүүл мэндийн хувьд хохирч болно.	<ol style="list-style-type: none"> 1. Эцэг эх, хүүхдээс учир шалтгааныг нь асууж болно. 2. Нийгмийн ажилтандаа болон хамтарсан багт мэдэгдэнэ.
Хүүхдүүд бие биенээ шоглож зодож байвал	Эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирч болно.	<ol style="list-style-type: none"> 1. Хүүхдүүдийн эцэг эхэд хэлнэ. 2. Сургуулийн нийгмийн ажилтанд мэдээлнэ. 3. Хүүхэд сургуульд сурдаггүй бол, хамран сургах тойргийн сургууль байхгүй бол нийгмийн ажилтандаа хэлнэ.


 **Асуулт: Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ юуг анхаарах вэ?**


 **Хариулт:** Юуны өмнө хүүхдийн аюулгүй байдлыг хангахад анхаарна. Хүүхэд амь нас, эрүүл мэндэд нь ноцтой аюул учруулж болзошгүй газар, хүмүүсээс хол байх ёстой. Ийм нөхцөлд байгаа хүүхдийн талаар яаралтай мэдээлж хүүхдийг аюулаас холдуулах хэрэгтэй. Өөр нэг анхаарах зүйл бол хүүхдэд тусалж байна гээд хүүхдэд нэмж гэм хор учруулж болохгүй. Хүүхдийн эмзэг, хүнд байдалд байгааг олон нийтэд зарлах, шаардлагагүй үед бусдын асрамж, халамжид засаг даргын зөвшөөрөлгүй шилжүүлэх зэрэг нь хүүхдэд тус болох гээд гэм хор учруулж буйн жишээ юм. Хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа хүн бүр мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй. Хүүхдэд хамгааллын үйлчилгээг зөвхөн мэргэжлийн хүмүүс л үзүүлнэ. Тэд бол нийгмийн ажилтнууд болон хамтарсан багийн гишүүд юм.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дүгээр зүйлд

10.2. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.

10.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд нь тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна гэж заасан.

 **Асуулт: Манай хэсгийнхэн чинь бие биенээ танина. Хэний хүүхэд ямар байдалтай явж байна гээд мэднэ шүү дээ. Тэгэхээр ямар мэдээлэл нь нууц байх ёстой юм бэ? Ямар ёсзүйн сахих вэ?**

 **Хариулт:** Танай хэсгийн хүмүүс бие, биенээ сайн мэддэг гээд гэр бүлийн дотоод асуудал, хүүхдэд тохиолдож байгаа зовлон бэрхшээлийг хамтарсан багийн гишүүдээс өөр хүмүүст ярьж задруулж болохгүй. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй бүх хүмүүс хүүхэд хамгааллын ёсзүйн дүрмийг баримтлах үүрэгтэй. Ёс зүйн дүрмэнд дараах агуулгыг багтаасан байдаг.

1. Хүүхдийн эсрэг хууль бус эсвэл аюултай үйлдэл гарсан тохиолдолд түүнийг заавал мэдээлэх ёстой.
2. Хүүхдийг ялгаварлан гадуурхах ямар ч үг үйлдэл гаргах ёсгүй.
3. Хүүхдийг цохих, зодох зэргээр бие махбодын шийтгэл үзүүлэхийг хатуу хориглоно.
4. Хүүхдүүдтэй бэлгийн харилцаанд өдсөн тоглоом тоглож болохгүй бөгөөд, бусдад тийм боломж олгох ёсгүй.
5. Хүүхэдтэй бэлгийн харилцаа үүсгэхийг хатуу хориглоно.
6. Хүүхэд том хүн хоёрын эрх мэдлийн зөрөөг ойлгож хүүхдэд дээрэнгүй хандахгүй байх ёстой.
7. Хүүхдийн сэтгэл санаанд хор нөлөө учруулах үг, бүдүүлэг үг, хараал хэрэглэж болохгүй.
8. Хороо, хэсгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд хамрагдаж буй хүүхдүүдээс хэн нэгнийг нь бусдаас онцгойлон анхааран халамжлахгүй байх ёстой.

9. Хүүхдийн зургийг авахдаа өөрөөс нь болон эцэг эх, асран хамгаалагчаас нь зөвшөөрөл авах бөгөөд зураг авахуулах сонирхолгүй бол саналыг нь хүндэтгэх хэрэгтэй.

Хувь хүний нууцыг хамгаалах тухай хуулинд хувь хүнийг захидал харилцааны нууц, эрүүл мэндийн нууц, хөрөнгийн нууц, гэр бүлийн нууц, хуулиар тогтоосон бусад нууцтай байхаар заасан. Тус хуулийн 5-р зүйлд

1. Хувь хүн нууцаа өөрөө хамгаална.
2. Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно.
3. Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана.
4. Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.

Хэдийгээр таны хариуцдаг хэсгийн хүүхэд, түүний гэр бүлд асуудал гарсан ч гэсэн тэд хувь хүнийхээ хувьд нууцаа хамгаалуулах эрхтэй. Тиймээс хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэрээр хамаг амьдралыг нь таних, танихгүй хүнд задалж болохгүй нь байна. Тиймээс хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг харсан, мэдсэн, сонссон зүйл байвал хуулиар үүрэг хүлээсэн, зөвхөн мэдэх ёстой хүнд нь л мэдээллийг дамжуулах ёстой. Энэ хүн бол хүүхэд хамгааллын тухай хуулиар үүрэг хүлээсэн хороо/баг/сумын нийгмийн ажилтан болон хамтарсан багийн гишүүд. Хамтарсан баг ажиллах явцдаа мөн хувь хүний нууцыг чанд сахиж, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх ёстой.





Асуулт: Хүүхдийн эрхийг хангахад иргэд ямар үүрэг, оролцоотой байх вэ?



Хариулт: Хүүхдийн эрхийн тухай хуулиар иргэн хүүхдийн эрхийн зөрчлийн талаар мэдвэл заавал холбогдох байгууллагад мэдээлэх үүрэг хүлээсэн.

18 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

18.1. Хүүхдийн эрхийг хангах талаар иргэн хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

18.1.1. хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд мэдээлэх;

18.1.2. хүүхдэд эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд санаачлага гаргах, дэмжих;

19 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн талаар мэдээлэл өгөх, гомдол, нэхэмжлэл гаргах

19.1. Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжид заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргана.

19.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, баг, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд хүсэлт, шаардлага гаргаж болно.

19.3. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, хүүхэд хамгаалахтай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

Хүүхдийн эрхийн тухай хууль

ӨӨРИЙГӨӨ ШАЛГАХ СОРИЛ

Хэсгийн ахлагчийн хувьд таны хариуцдаг хэсэгт амьдардаг нэгэн хүү таньтай таарах болгонд айсан, түгшсэн, заримдаа нүүр нь хөхөрсөн байдалтай харагддаг. Хүүхдүүд хичээлдээ явах ёстой цагт гудамжинд таардаг байна гэж бодож, төсөөлөөд дараах асуултад хариулья.

1. Хүү хүчирхийлэл дарамтад өртсөн байж болох уу?
 - А. Үгүй. Учир нь би хараагүй учраас нотолж чадахгүй.
 - Б. Тийм. Хүүхдийн биед гарсан шинж тэмдэг нь хүчирхийлэлд өртсөн байж болохыг харуулж байгаа тул шалгах шаардлагатай.
2. Хүүхэдтэй тааралдвал
 - А. Тоолгүй орхино.
 - Б. Уулзаад би чамд юугаар туслах вэ гэж асууна.
3. Хүүгийн тухай мэдээллийг хамтарсан багийн гишүүдэд өгөх эсэх асуудлаар
 - А. Одоогоор ямар нэгэн ноцтой зүйл болоогүй тул хэнд ч хэлэхгүй.
 - Б. Нийгмийн ажилтандаа мэдэгдэж, хүүтэй уулзахыг санал болгоно.
4. Хүүгийн талаарх мэдээллийг хэнд өгөх вэ?
 - А. Хүүхдийн талаар асуусан болон сонирхсон хэн бүхэн
 - Б. Зөвхөн нийгмийн ажилтан болон хамтарсан багийн гишүүдэд
5. Хэзээ мэдээлэх вэ?
 - А. Хүүг судалж, нэлээн баримттай болсны дараа
 - Б. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж болохыг ажигласан даруйдаа

Хэрэв дээрх энгийн асуултын Б гэсэн хэсгүүдийг бөглөсөн бол та хүүхэд хамгааллын талаар сайн ойлгосон бөгөөд мэдээлэх үүргээ сайн биелүүлэх юм байна.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ.

НОМ ЗҮЙ

- Жоан Е Дюррант (2007). Хүмүүжлийн эерэг арга. Юу? Яаж? УБ
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 30/24–р тогтоол, Хэсгийн ахлагчийн ажиллах журам, 2015 оны 10 сарын 30
- УИХ (2016). Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ
- УИХ (2016). Хүүхэд хамгааллын тухай хууль, УБ
- УИХ (1995). Хувь хүний нууцыг хамгаалах тухай хууль, УБ



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.